

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

CHANG MING

**УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНД ЖҮРҮР НЭРИЙН ДОР
ХЭРЭГЛЭГДДЭГ ЭМИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА**

Е-09160101 Эм зүй

Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар хот
2016 он

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

CHANG MING

**УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНД ЖҮРҮР НЭРИЙН ДОР
ХЭРЭГЛЭГДДЭГ ЭМИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА**

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

Эм зүйн ухааны доктор Д.Даваадагва

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

Эм зүйн ухааны доктор, дэд профессор С.Пүрэвсүрэн

Улаанбаатар хот
2016 он

Уламжлалт анагаах ухаанд Жүрүр нэрийн дор хэрэглэгддэг эмийн түүхий эдүүдийн эх сурвалжийн харьцуулсан судалгаа

Судалгааны ажлын үндэслэл

Монголын уламжлалт анагаах ухаан нь монгол хүний бие махбодь оюун санаа, сэтгэл зүйн онцлог, нүүдэлчдийн ахуй нөхцөл, ёс заншилтай зохицсон өөрийн өвөрмөц төрхтэй бие даасан, эрдэм мэдлэг оюуны соёлын нандин өв мөн. Уламжлалт анагаах ухаан нь монгол үндэстний өвчин эмгэгтэй тэмцэж ирсэн урт удаан түүхэн хугацаанд хуримтлуулсан туршлагын явцад Хятад, Төвд, Энэтхэгийн анагаах ухааны онол, баялаг туршлагаас уламжлан авч монгол үндэстний онцлогийг тусгасан биеэ даасан анагаах ухаан болон хөгжиж чадсан юм. Homo sapiens буюу ухамсарт хүн үүссэн цаг хугацаатай эн чацуу настай анагаах ухааны уламжлалт аргуудад ашиглагддаг эрдэс, амьтан, ургамлын гаралтай байгалийн бүтээгдэхүүнд нь одоо ч гэсэн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, урт наслуулах зорилгоор дэлхий даяар өргөн хэрэглэгдсээр байгаа билээ.¹

Дэлхийн олонх улс оронд байгалийн гаралтай хор, гаж нөлөө багатай эмийн бэлдмэлд ихээхэн ач холбогдол өгч байгааг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас сайшаан дэмжсэн бодлого явуулж байгаагийн тоонд ургамал, амьтан, эрдсийн гаралтай биологийн идэвхт нэгдлүүд орох бөгөөд манай орны хувьд олон зуун жилийн туршид уламжлалт анагаах ухааны (УАУ) өвөрмөц эм, тан хэлбэрээр хэрэглэж ирсэн онцлогтой дан болон олон найрлагатай жорууд орох боломжтой юм.

Бидний судалгааны материал болох Жүрүрийг эртний ном сударт өөр өөр нэрээр тэмдэглэсэн байдаг. Хятадын эртний зохиол болох “Өвсөн эмийн судар”-т Жүрүрийг “Жүчи” гэсэн нэрээр тэмдэглэсэн байдаг бөгөөд орчин үед Жүрүрийг шар жүр үр, жижиг жүр үр гэсэн нэрээр тэмдэглэсэн байна. Жүрүрийг Энэтхэгийн УАУ-нд *Phyllanthus emblica* L, Хятадад *Gardenia jasminoides* Ellis. нэрийн дор хэрэглэж байсан ба манай орны хувьд эрт дээр үеэс овог төрөл нь өөр боловч амт чадлаар ойролцоо Долоогоно (*Grataegus sanguina* Pall.)-оор Жүрүрийг орлуулан нутгийн Жүрүр хэмээн нэрлэн хэрэглэсээр ирснийг шинжлэх ухааны үндэслэлтэй батлахыг зорисон нь эдгээр эмийн түүхий эдүүдийн эх сурвалжийг харьцуулсан судалгаа хийх үндэслэл болсон юм.

Судалгааны ажлын зорилго, зорилт:

Жүрүр нэрийн дор хэрэглэгддэг эмийн түүхий эдүүдэд эх сурвалжийн болон зарим биологийн идэвхит нэгдлээр харьцуулан судлах зорилго тавилаа.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн.

- Жүрүр нэр дор хэрэглэгддэг эмийн түүхий эдүүдэд эх сурвалжийн харьцуулсан судалгаа хийх
- Судалгааны материал болох дээрх 3 ургамлын физик химийн чанарын үзүүлэлтүүдийг тогтоож, зарим биологийн идэвхит нэгдлийг харьцуулан судлах

Судалгааны ажлын материал, арга зүй

Эх сурвалжийн судалгааны материал

Монгол уламжлалт анагаах ухааны түүхтэй холбогдолтой эх сурвалжуудыг агуулсан Хятад, Төвд, Монголын анагаах ухааны түүхийн зохиолууд: “Жингун”, “Сомаранз”, “Үзэсгэлэнт нүдэн чимэг”, “Жүдшин дадол”, “Рашааны хурим”, “Хиргүй болор эрхи”, “Дөрвөн рашаан” зэрэг гол зохиолууд багтаж байна.

Архивын материалууд

ӨМӨЗО-ны Төв номын сан, Монгол Улсын Үндэсний Төв номын сангийн архивт хадгалагдаж байгаа түүхэн материалуудыг судалж ашиглав.

Түүнчлэн БНХАУ-ын Бээжингийн Хятад эм, эмнэлгийн их сургуулийн академийн музей, ӨМӨЗО-ны Тунляо хотын Монгол эм, эмнэлгийн дээд сургуулийн музей, анагаах ухааны түүхтэй холбоотой эх сурвалжууд

Уламжлалт анагаах ухааны талаархи өвгөдөөс ам дамжин ирсэн хууч яриа, түүх домгийг ашигласан болно.

Түүхий эдийн судалгааны ажлын материал, хэрэглэгдэхүүн

- (*Gardenia jasminoides Ellis.*)-ний үр, жимс БНХАУ Жүрүрийг Өвөр Монголын Лиүчэн эмийн сангаас. Үйлдвэрлэсэн газар Шандун цувралын дугаар 20150702.
- (*Phyllanthus emblica*)- ний үр, жимс БНХАУ 2015 оны 7 сард Өвөр Монголын Лиүчэн эмийн сангаас . Ургасан газар Юннан цувралын дугаар 20150702.
- Долоогоно (*Grataegus sanguine. Pall*) - Улаанбаатар хот Сонгино Хайрхан дүүрэг, Сонгино орчимоос бэлтгэсэн.

Судалгааны ажлын үр дүн, дүгнэлт

1. Жүрүр нэрийн дор хэрэглэгддэг 3 овгийн 3 зүйлийн ургамлын амт, чанар, чадалыг уламжлалт анагаах ухааны түүхэн ном зохиолуудад тэмдэглэгдсэнийг харьцуулан судлахад амт нь адил боловч чанар, чадал болон ургамлын хэлбэр дүрсээрээ ялгаатай байлаа.
2. Жүрүр нэрийн дор хэрэглэгддэг *Gardenia jasminoids* Ellis., *Pyllantus embelicca* L., *Crataegus sanguine* Pall. зэрэг ургамлын түүхий эдүүдэд гадаад байдал, өнгө, үнэр, амт, чийглэг, хүнд металлын агууламж, макро, микро элементийн агууламж, микробиологийн цэвэршилт зэрэг үзүүлэлт нь зөвшөөрөгдөх хэмжээнд байсан ба *Gardenia jasminoids* Ellis.-д жүрүрийн гликозид 3.15-3.32мг/г, *Phyllantus embelica* L. –д рутин 0,9 мг/г, *Phyllantus embelica* L.–д галлын хүчил 0,73 мг/г, түүхий эд тус бүрт нийлбэр органик хүчил (*Phyllanthus embelica* Linn.)-д 14,169%, (*Gardenia jasminoides* Ellis.)-д 13,227%, *Crataegus sanguine* Pall.-д 4,46% тус тус хэмжээтэй агуулагдаж байна.

Comparative study of the sources of medicinal raw materials is used under name Jürür of Traditional Medicine

Introduction

At present, a growing tendency to introduce traditional medicine modern medical practice has been used by many thousands of years, traditional medicine has been increased to ensure that traditional drug efficacy, safety and quality.

Jur ur ancient books to our research, the scriptures are marked by a different name. Chinese ancient literature is marked with the name of "grass drug scripture" in Jur ur "Juchi" It is now marked with the name such as mountain Jur ur, soy Jur ur and small Jur ur.

Jur ur was used under the name of Indian medicinal that is *Phyllanthus emblica* L, name of Chinese medicinal that is *Gardenia jasminoides* Ellis. and in our country *Grataegus sanguine* Pall. and *Mali baccatae* were used under the name of Jur ur. Their plants that are different species but treatment activities of their plants were same resulted. It has needed to confirm a result with evidence of sciences because we should compared study in plants of raw materials

Goals

Jur ur that are *Gardenia jasminoides* Ellis, *Grataegus sanguina* Pall. and *Phyllanthus emblica* L. be studied to compared novels medical history and some of the biologically active compounds contained in raw materials of their plants

Methods and materials

Materials of source research

China, Tibet, Mongolia novels medical history of related Mongolian history of traditional medicine texts: "Jingun" and "Somaranz" and "Beautiful sight retro" and "Jüdshin dadol" and "spa wedding" and "Khirgüi crystal rosary", " four springs" are included in the main texts ".

Archival materials

Inner Mongolia Autonomous Region Library, used to study materials National Center of Mongolian history book stored in library archives.

In addition, China's Beijing Chinese medicine, Medical University Academy Museum, the region has Tongliao resources on the city Mongolian medicine, medical university museums and medical history through illnesses from fathers of medicine can be used in the legend of speech and history.

The fruits and seeds of *Gardenia jasminoides* and *Phyllanthus emblica* L, used as experimental material, were collected in Yunan, Uvurmongol, in July and were bough Liuchen pharm of China.

We identified by the trial methods that are the general reaction testing and chromatographic methods such as TLC, HPLC and some of the biologically active compounds contained in their herbal raw materials

Results and conclusion of study

1. Jürür behalf paragraph 3 under tribal 3 plants used to flavor, quality and taste in comparing strength noted in the literature history of medicine book. was different from the same, but the quality, capacity and plant form.

2. *Gardenia jasminoids* Ellis., *Pyllantus embelicca* L., *Crataegus sanguine* Pall. used under Jürür name, raw tissues of plants appearance, color, aroma, flavor, moist and heavy metal content, macro and micronutrient content, and indicators such as microbiological purity to an acceptable level and *Gardenia jasminoids* Ellis.-jürüriin glycosides 3.15-3.32mg / d, *Phyllantus embelica* L. in rutin, 0.9 mg / d, *Phyllantus embelica* L.-gallic acid is 0.73 mg / g, and each material in composite organic acid 14.169% - (*Phyllanthus embelica* Linn.), (*Gardenia jasminoides* Ellis.) 13,227% and 4.46%-*Crataegus sanguine* Pall. is each contained the amount.